



ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/17

Алтрага

Орон тооны бус зөвлөлийг татан  
буулгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, "Тушаал хүчингүй болгох тухай" Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/20 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 1/318 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу Даатгуулагчийн малчнаар ажиллаж нийгмийн даатгалын шимтгэл төлсөн хугацааг тодорхойлох Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийг татан буулгасугай.

2.Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөлийн шийдвэр, хурлын тэмдэглэл, бусад холбогдох баримт материалыг аймгийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлэхийг УЗөвлөлийн нарийн бичгийн дарга, нийгмийн даатгалын байцаагч (Д.Отгонбаяр)-д үүрэг болгосугай.

3."Засаг даргын дэргэдэх орон тооны бус байнгын зөвлөл байгуулах тухай" сумын Засаг даргын У2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/137 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга)-д даалгасугай.

ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010041